



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Кокс заг эрчим” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **ӨМА-2022/21/НА-СТА-ОНӨААН**

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2022 он	Өмнөговь аймаг дахь төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр Утас: 70533539, Цахим хаяг: tserenbayars@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 705335528, Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Эн Ай Ти Эс баланс аудит ХХК Захирал: Ш.Ичинхорлоо Утас: 77280808 Цахим хаяг: tavanchuluu.ts@moaudit.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

БУЛГАН СУМЫН "КОКС ЗАГ"
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
Н.ОТГОНБААТАР ТАНАА

2022.03.15 № 263
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Өмнөговь аймгийн Кокс заг" ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Кокс заг" ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 470 дугаар тогтоолоор дулааны эрчим хүчний тарифыг шинэчлэн тогтоосон ба Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 50 дугаар тогтоолоор цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг тус тус шинэчлэн баталсантай холбоотойгоор сумын дулаан, бохир, цэвэр усны үнэ тариф шинэчлэгдсэн байна.

Аудитын гол асуудлууд

Тайлант онд Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн "Коронавируст халдварын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай" 211 дүгээр тогтоолын хүрээнд 17.3 сая төгрөгийн дулааны, 8.8 сая төгрөгийн цэвэр бохир усны, нийт 28.5 сая төгрөгийн төлбөрийн санхүүжилт авахаар тооцож, гүйцэтгэлээр дулааны 16.8 сая, цэвэр бохир усны 6.8 сая, нийт 23.6 сая төгрөгийн төлбөрийн санхүүжилтийг авч, үлдэгдэл 4.9 сая төгрөгийг авлагын дансанд бүртгэсэн байна.

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Тайлант хугацаанд "Коксзаг" ОНӨААТҮГ үйл ажиллагааныхаа цар хүрээг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийн тав тухтай байдлыг хангах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэснээр төлөвлөгдөөгүй 56.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Тухайлбал, цэвэр бохир усны нэгдсэн системд хэрэглэгчдийг нэмж, шинээр ашиглалтад орсон спорт заалны халаалтын талбайг дулааны шугамд холбосон, Булган сумын 5

ЗДТГ, Говийн оюу орон нутгийн хөгжлийг дэмжих сантай хамтран ухаалаг худаг суурилуулах ажлыг гүйцэтгэж, цэнэглэдэг усны карттай болсон байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЦЭРЭНБАЯР

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	121,866,472.80	160,166,571.64
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,566,633,806.85	1,542,610,800.05
	Нийт хөрөнгийн дүн	<u>1,688,500,279.65</u>	<u>1,702,777,371.69</u>
	Нийт өр төлбөрийн дүн	1,390,699,622.18	1,364,327,725.86
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	297,800,657.47	338,449,645.83
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	<u>1,688,500,279.65</u>	<u>1,702,777,371.69</u>
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	228,743,932.46	341,447,073.86
	Үйл ажиллагааны зардлын дүн	220,638,867.42	311,433,411.07
	Үйл ажиллагааны үр дүн	<u>188,316.47</u>	<u>40,648,988.36</u>
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	<u>188,316.47</u>	<u>40,648,988.36</u>
	Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	<u>138,546,729.00</u>	<u>235,447,007.15</u>
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	62,165,333.85	62,165,333.85
	Тайлант оны үр дүн	188,316.47	40,648,988.36
	Эцсийн үлдэгдэл	<u>235,447,007.15</u>	<u>338,449,645.83</u>
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	266,556,927.03	365,636,591.33
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	207,992,766.51	316,950,133.42
	Үйл ажиллагааны ЦМГ	<u>58,564,160.52</u>	<u>48,686,457.91</u>
	Хөрөнгө оруулалтын ЦМГ		
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	16,123,983.75	74,688,144.27
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<u>74,688,144.27</u>	<u>123,374,602.18</u>
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		278,171,700.00
	Урсгал зардал		278,171,700.00
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		280,928,700.00
	Улсын төсвөөс санхүүжих		
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		280,928,700.00

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагаа

“Кокс заг эрчим” ОНӨААТҮГ нь эрхэм зорилгоо Орон нутгийн гол хөшүүрэг болсон дулаан, эрчим хүчийг үр ашигтай үйлдвэрлэн явуулж хэрэглэгчийн таатай, тухтай орчныг бүрдүүлэн тасралтгүй найдвартай ханган үйлчилж ажиллалахад оршино гэж тодохойлсон байна.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хөгжүүлэн шинэ шатанд гаргахын тулд сум хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд үйл ажиллагааны чиглэл болон дулаан хангамжийн шилдэг шинэ техник, технологийг нэвтрүүлж үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд шинэлэг санааг хэрэгжүүлж ажиллах хэтийн зорилготой.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ОНӨААТҮГ гэсэн статустай байна. Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар статустай ба өмчийн 100.0 хувийг төр эзэмшиж байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

“Кокс заг эрчим” ОНӨААТҮГ-ыг Өмнөговь аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдын 1998 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр тогоолоор байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

“Кокс заг эрчим” ОНӨААТҮГ захирал нь “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”, “Компанийн тухай хууль” болон бусад хууль, тогтоомжийг үндэслэн Аймгийн засаг даргатай 2021 оны 05 дугаар сарын 28-ны өдөр нэг жилийн гэрээ байгуулан ажиллаж байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Кокс заг эрчим” Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн данс, балансын данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 16-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд “Эн Ай Ти Эс баланс аудит” ХХК-ийн аудитор Г.Хүрэл гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер И.Туяа хэрэгжүүлж, захирал Ш.Ичинхорлоо, хоёр дахь шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

“Кокс заг эрчим” Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь 2021 оны санхүүгийн тайлангаа хооронд “Эн Ай Ти Эс баланс аудит” ХХК-д 2022 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 02/2022 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдлийн талаар авч үзэх.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 107.8 сая төгрөгийн 2 алдаа зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 107.8 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшинээс их хэдий ч санхүүгийн тайланд нөлөөлөлгүй тул “Зөрчилгүй дүгнэлт өгөхөөр шийдвэрлэв.

Залруулсан алдаа байхгүй болно.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	/сая төгрөгөөр/									
		Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	“Кокс заг эрчим”	2	107,807.4							2	107,807.4
	НИЙТ ДҮН	2	107,807.4							2	107,807.4

